## "БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ
## 2019 ОНЫ 12 ДУГААР САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр — Багануур дүүрэг

| № | ҮНДЭСЛЭЛ | ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ |
|---|---|---|---|
| 1 | "БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 17.1. | Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлын хүрээнд:<br>- 2019.12.03-ны өдөр Эрчим хүчний хэрэгжилтийн газрын хурал БХБЯ, БХТ, Мон-Энержи Консалт ХХК, НШУҮИГ, БҮТП-ийн дарга, мэргэжилтнүүдийн оролцож паркийн цахилгаан хангамжийн техник нөхцөлийг олгуулах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн.<br>- ЭХЯ-ны Диспетчерийн үндэсний төвтэй гэрээ байгуулан цахилгаан хангамжийн горим ачааллын тооцоог гүйцэттүүлж байна.<br>- "Барилга хөгжлийн төв"-өөс томилсон экспертийн магадлалаар паркийн инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл хянагдаж, нэгдсэн дүгнэлт гаргахад бэлтгэж байна. | 100% |
| 2 | 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.1 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай паркийн дарга биечлэн уулзаж паркийн өнөөгийн байдал, хөрөнгө оруулалтын санал болон хүнд үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтцийг Багануур ХК-ийн дэд бүтцийг түшиглэн байгуулах боломж зэргийг танилцуулсан. Нийслэлийн Засаг дарга цахилгаан хангамжийн эх үүсвэрийг байгуулах 110x35 2x25000 кВт хүчин чадалтай дэд станцын зураглал, тооцооллыг ирүүлэхийг үүрэг болгосон.<br>Диспетчерийн үндэсний төв нь паркийн цахилгаан хангамжийн горим ачааллын тооцоог боловсруулж дууссаны дараа цахилгаан хангамжийн эх үүсвэрийг байгуулах 110x35 2x25000 кВт хүчин чадалтай дэд станцын зураглал, тооцооллыг хүргүүлэхээр төлөвлөж байна. | 100% |
| 3 | Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж | Паркийн "Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв"-ийн барилгын зураг төслийг Нутаг Консалт ХХК боловсруулж байна. Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газраас архитектур төлөвлөлтийн даалгаврыг баталж, нэршлийг "Үйлдвэрийн албан контор"-ын барилга болгон өөрчилсөн. Паркийн зүгээс байршлыг тодорхойлох, холбогдох бичиг баримтуудыг гаргах, хангагч байгууллагуудаас техникийн нөхцөл гаргуулах ажилд оролцож, гүйцэтгэлд хяналт тавьж байна. Барилгын ажлын зураг холбооны техникийн нөхцөл авах ажлаас хамаарч ондоо багтаан гүйцэтгэх боломжгүй болсон. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | | Багануур үйлдвэрлэл, технологийн парк төслийн "Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгүүлэх ажлын хүрээнд:<br>- "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам"-ын дагуу БОННҮ-ний тайланг 2019.12.04-ний өдөр 5 хороодын Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэхэд 6 иргэд асуулга, санал тавьж, 25 хүн бичгээр саналаа өгч, олонхийн саналаар тайланд "ХАНГАЛТТАЙ" гэсэн дүгнэлт өгч паркийн үйл ажиллагааг дэмжих нь зүйтэй гэж үзсэн.<br>- Дүүргийн 1, 2, 5 дугаар хорооноос ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, 3, 4 дүгээр хорооноос паркийн төслийг дэмжсэн тухай албан бичгийг гарган 2019.12.10-ны өдөр хүргүүлсэн.<br>- Мөн үнэлгээний тайланд паркийн зүгээс өгөх саналаа Санни трейд ХХК-д уламжилсан.<br>- Гүйцэтгэгч байгууллага нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг БОАЖЯ-аар батлуулахаар хянуулж байна. | 100% |
| 5 | 2019 оны Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1 | - Паркийн ТУЗ байгуулах өнгөрсөн оны судалгаанд тулгуурлан нийслэлийн бусад паркуудтай харьцуулан шинжилж ТУЗ байгуулах нөхцөл хараахан бүрдээгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч даргад танилцуулав. | 100% |
| 6 | 2019 оны Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.4 | - Паркад кластерын удирдлагыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх арга зам, ач холбогдлыг судалж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон. | 100% |
| 7 | 2019 оны Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.1 | - ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо ISO 18001:2007, ISO 45001:2018 стандартын хоорондын ялгаа, ач холбогдол, баталгаажуулалтын схем, дэлхийн жишгийг судлан судалгааны материалыг боловсруулсан. Цаашид уг стандартыг нэвтрүүлэх арга замыг тодорхойлно.<br>- ХАБЭА-н талаарх үндсэн үзүүлэлт болон үйлдвэрийн ослын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэн Монгол улсад мөрдөгдөж буй ХАБЭА-н стандартуудыг хавсаргасан судалгааны материалыг боловсруулав. | 100% |
| 8 | 2019 оны Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний 3 | - Украины үйлдвэрлэл, технологийн парк, БНСУ-ын аж үйлдвэрийн паркуудын талаарх судалгааг нэгтгэж удирдлагад танилцуулсан. | 100% |
| 9 | 2019 оны Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2, 1.3 | - Парк-Суралцагч байгууллага болох зорилтын хүрээнд ЭШИИСТ-ийн барилгыг засварлах, ашиглах талаар дотооддоо хэлэлцүүлгийг зохион байгуулав.<br>- Парк суралцагч байгууллага болох, Парк инновацич байгууллага болох төлөвлөгөөнүүдийн биелэлтийг гаргаж дүгнэлт өгч цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлов. | 100% |

<table>
<tr>
<td>10</td>
<td>2019 оны Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.1</td>
<td>- ШАУИС, ШУТИС, ХААИС, УХЭШХ-тэй байгуулсан гэрээ, санамж бичгийн дагуу баталсан хамтын ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, хамтран дүгнэхээр бэлтгэж байна.</td>
<td>100%</td>
</tr>
<tr>
<td>11</td>
<td>Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж</td>
<td>
Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг хангаж ажиллав.
“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар нийт 189 бичиг ирснээс хариутай бичиг 72, хариутай бичгийн шийдвэрлэлт 94.29%, хариугүй бичгийн хаалт 98.00%, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 94.48%-тай байна.
“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас 2019 оны 12 сарын 27-ны өдрийн байдлаар яам, нийслэл, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад нийт 248 албан бичиг явуулсан байна.
Баримт бичгийн шийдвэрлэлтийг графикаар харуулав.
<table>
<tr><th>№</th><th>Үзүүлэлтүүд</th><th colspan="5">Улирлын мэдээ/хувиар/</th></tr>
<tr><th></th><th></th><th>I</th><th>II</th><th>III</th><th>IV</th><th>Нийт</th></tr>
<tr><td>1</td><td>Нийт ирсэн бичгийн тоо</td><td>24</td><td>52</td><td>36</td><td>77</td><td>189</td></tr>
<tr><td>2</td><td>Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт</td><td>97.69</td><td>95.22</td><td>90.06</td><td>94.60</td><td>94.49</td></tr>
<tr><td>3</td><td>Хариутай бичгийн шийдвэрлэлт</td><td>100</td><td>95.24</td><td>89.29</td><td>92.50</td><td>94.29</td></tr>
<tr><td>4</td><td>Хариугүй бичгийн хаалт</td><td>88.46</td><td>95.16</td><td>93.18</td><td>98.00</td><td>98.00</td></tr>
<tr><td>5</td><td>Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/хоног</td><td>8.58</td><td>15.48</td><td>12.67</td><td>5.00</td><td>9.83</td></tr>
<tr><td>6</td><td>Зөрчилтэй албан бичиг</td><td>0</td><td>1</td><td>3</td><td>0</td><td>4</td></tr>
</table>
- Байгууллагын нэр андуурч илгээсэн зөрчил 4 байна. Зөрчлийн дэлгэрэнгүй мэдээг ашиглан зөрчил гаргахгүй байхад анхаарч ажилласны үр дүнд 2019 оны 04 дүгээр улиралд өмнө гаргасан зөрчил давтагдаагүй.
</td>
<td>100%</td>
</tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | | - Бүртгэл хяналтын картыг 2019 оноос эхлэн хариутай бичигт хөтлөн ажилласан. | |
| 12 | Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоол | Байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 47 дугаар тушаалын 8 дугаар хавсралтын дагуу гаргаж дүүргийн ЗДТГ-ын ТЗУХ-т 2019.12.17-ны өдрийн 226 дугаар, нийслэлийн ЗДТГ-ын ТЗУХ-т 2019.12.25-ны өдрийн 248 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв. | 100% |
| 13 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын 1 дүгээр хавсралт | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нэгдсэн сан бүрдүүлэх журмын дагуу дараах тайлангуудыг хугацаанд нь зохих газарт хүргүүлж ажиллав. Үүнд:<br>1. Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр<br>2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл<br>3. Дэд хөтөлбөрийн хэрэгжилт<br>4. Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл<br>5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлт, дүн мэдээ<br>6. Нийслэлийн Засаг даргын Захирамжийн биелэлт<br>7. Байгууллагын 2019 оны үйл ажиллагааны бичмэл тайлан<br>8. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг зохион байгуулсан ажлын тайлан<br>9. Удирдлагын иргэдтэй хийсэн уулзалтын тайлан<br>10. Албан бичгийн шийдвэрлэлтийг зохион байгуулсан ажлын тайлан<br>11. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан<br>12. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлан<br>13. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийн мэдээ<br>14. Гадаад харилцааны үйл ажиллагааны тайлан<br>15. "Иргэдийн оролцоотой – Хөгжлийн жил"-ийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн тусгай төлөвлөгөөний биелэлт<br>16. "Иргэдийн амьдрах орчныг сайжруулах жил"-ийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан<br>17. Нийслэлийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс ирүүлсэн зөвлөмжийн тайлан<br>18. Дүүргийн ЗДТГ-ын ТЗУХ-ээс ирүүлсэн зөвлөмжийн тайлан | 100% |
| 14 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль | Дөрөвдүгээр улирлын материалын тайланг гарган, Паркийн даргын 2019 оны А/35 дугаар тушаалын дагуу 2019.12.16-нд байгууллагын жилийн эцсийн тооллогыг явуулж Илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан. | 100% |
| 15 | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2, 3.7 | Байгууллагын цахим хуудсанд ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн дагуу жилийн эцсийн биелэлтүүд болон мэдээллийг оруулж баяжилтыг хийсэн. | 100% |

| НЭМЭЛТ АЖИЛ | | |
|---|---|---|
| 1 | “Нэг хот-Нэг стандарт” анхдугаар зөвлөгөөний үр дүнд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн үүрэг чиглэлтэй танилцан хэрэгжүүлж эхлээд байна. Хэрэгжилтийн биелэлтийг улирал бүр тайлагнан ажиллахаар төлөвлөж байна. | 100% |
| 2 | Засгийн газрын 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам” болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн “2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.2.7-д заасан “Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцооны систем, тоон гарын үсгийг нэвтрүүлэх” ажлын хүрээнд 2019.12.06-нд нийслэлийн Мэдээллийн технологийн газраас тоон гарын үсгийн э-Токен төхөөрөмжийг хүлээн авсан. | 100% |
| 3 | “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ы хүрээнд дараах сургалтуудад хамрагдав. Үүнд:<br>- 2019.12.02-нд дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтсээс “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ы хүрээнд “Ойлгоё хүндэлье – Гэр бүлийнхээ төлөө” уриан доор зохион байгуулж буй уулзалтад Үйлдвэрлэл,технологийн кластер инженер оролцож, тус аянд нэгдэв.<br>- Мөн 2019.12.06-ны өдөр Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтсээс зохион байгуулсан “Гэр бүлийнхээ төлөө” сэдэвт хэлэлцүүлэгт Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн инженер оролцож саналаа хүргэв.<br>- Нийслэлийн ЗДТГ-аас зохион байгуулж буй “Жендэр ба хөгжил” нийслэлийн анхдугаар чуулганд паркийн дарга болон Маркетинг, олон нийтийн харилцаа, хот хариуцсан мэргэжилтэн нар 2019.12.09-ний өдөр оролцов.<br><br>Аяны хүрээнд байгууллагын албан хаагч нарт мэдээллийг хүргэж, цахим хуудсанд “Ойлгоё хүндэлье – Гэр бүлийнхээ төлөө” уриалгыг байршуулж, мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулав. | 100% |
| 4 | - “Архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журам”-ын 3 дугаар зүйлд заасны дагуу 2019.12.01-ны байдлаар дүн тоог тусган баталгаажуулж, Нийслэлийн архивын газарт хүргүүлэхээр бэлтгэж байна.<br>- 2019.12.05-ны өдөр дүүргийн ЗДТГ-аас зохион байгуулсан Архивын салбар үүсч хөгжсөний 92 жилийн ойн баярын хурлад паркийн дарга болон Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн нар оролцож мэргэжилтэн М.Мөнхдулам дүүргийн Засаг даргын Баярын бичгээр шагнагдав. | 100% |
| 5 | “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах дүүргийн дэд хөтөлбөр”-ийн биелэлтийг гаргаж Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст 2019.12.13-ны өдрийн 227 дугаар албан бичгээр хүргүүлэв. | 100% |
| 6 | “Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар эрдэст, компост бордоо хийх аргачлал” сэдэвт танхимын сургалтыг дараах 4 байгууллагын нийт 51 албан хаагчдад зохион байгуулав.<br>- 2019.12.12-ны өдөр Албан бус-Насан туршийн боловсролын төвийн 13 албан хаагч<br>- 2019.12.13-ны өдөр БЗӨБЦТС ТӨХК-ийн 20 албан хаагч<br>- 2019.12.20-ны өдөр 1 дүгээр хорооны 15 албан хаагч<br>- 2019.12.20-ны өдөр Шуудан холбооны газрын 3 албан хаагч | 100% |
| 7 | Даргын зөвлөлийн хурлаар нийт албан хаагчдын болон Захиргаа, Үйлдвэрлэл, технологийн албаны 2019 оны үйл ажиллагааны жилийн эцсийн биелэлтийг үнэлэв. | 100% |

| | | |
|---|---|---|
| 8 | Багануур дүүргийн Засаг даргын 2019 оны А/412 захирамжаар батлагдсан "Дүүрэг соёл" дэд хөтөлбөртэй танилцаж, байгууллагын Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлд хэрэгжилтийг хариуцуулан 2020 оны 5 болон 11 дүгээр саруудад Нийгмийн хөгжлийн хэлтэст тайлагнаж ажиллахыг үүрэг болгов. | 100% |
| 9 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2019 оны А/1340 дугаар захирамжаар батлагдсан "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт-ийн Улсын үзлэгийн дүн болон цаашид анхаар ч ажиллах арга хэмжээ"-г нийт албан хаагч нарт танилцуулсан.<br>Мөн 2019.12.27-ны өдөр "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт-ийн Улсын үзлэгээр илэрсэн ололттой тал болон зөрчил дутагдал, цаашид авах арга хэмжээний тухай" мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, А үнэлгээ авсан байгууллагуудад Батламж гардуулах арга хэмжээнд оролцов. | 100% |
| 10 | Нийслэлийн мэдээллийн технологийн газраас зохион байгуулсан UB ERP дотоод удирдлагын системийн 2 дугаар шатны сургалтын материалын системээс татаж ашиглан дотооддоо сургалт зохион байгуулав. | 100% |
| 11 | 2019.12.06-ны өдөр Шинэ жилийн баярыг угтан бүх нийтийн их цэвэрлэгээг дүүргийн Захирагчийн ажлын албанаас зохион байгуулсан ба паркийн албан хаагчид хуваарьт 2 газрын цас, ил задгай хог хаягдлыг цэвэрлэж, тайланг хүргүүлэв. | 100% |

ТАЙЛАН ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

УЛААНБААТАР ХОТ
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨАТҮГ газар
УП00014 8184063
2715 109066

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.МИЧИД-ЭРДЭНЭ